

НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БОДЛОГО

"Болор мэлмий" эмнэлэг нь тусlamж, үйлчилгээний чанарыг эрхэмлэж, үйлчилүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээдэлсэн, ажиллагсадын хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг сахин хамгаалсан, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа бүхий Монгол улсын нүдний төрөлжсөн мэргэшлийн тэргүүлэгч эмнэлэг байхыг зорьж байна.

Бид өөрийн ажил, үйлчилгээний хүрээ, чиг үүргийн бүх түвшинд олон улсын ISO 9001:2015, ISO 14001:2015, ISO 45001:2018 стандартуудын шаардлагыг баримтлал болгон чанар хангах, хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй ажиллагаа, байгаль орчны эрсдэлийг үнэлж, үр дүнтэй удирдах "Нэгдсэн менежментийн тогтолцоо"-г бий болгон дараах зорилтуудыг нэн тэргүүнд хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулж, хөгжүүлэх болно.

- Холбогдох хууль, тогтоомж, стандарт, байгууллагын бодлого, журам, сонирхогч талуудын шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллана.
- Үйлчилүүлэгч болон түншүүдээ дээдлэн, тэдний хэрэгцээ, хүлээлтийг судалж тогтоосны үндсэн дээр сэтгэл ханамжиднийцсэн, чанартай үйлчилгээ үзүүлнэ.
- Эрсдэлд сууринсан сэтгэлгээ, дотоод хяналт, аудитын үйл ажиллагааг нэвтрүүлж, илрүүлсэн үл тохирлын суурь шалтгааныг судалж тогтоон, залруулах, сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлнэ.
- Чанар, Байгаль орчны хамгаалал, Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын зөв зан үйл, хандлага, соёл, дадлыг хэвшүүлэхийн тулд ажиллагсдад зориулан мэдээлэл, сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлнэ.
- Хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхүйц хог хаягдлын менежментийг зохицой зохион байгуулж, байгальд ээлтэй бүтээгдэхүүн, хэрэгслүүдийг үйл ажиллагаандaa ашиглах зарчим баримтлан ажиллана.
- Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, ажиллагсдын оролцоог нэмэгдүүлж, үр чадвар, чадамжийг тасралтгүй дээшлүүлж бус нутаг, дэлхийд жишиг болсон сайн туршлагуудаас суралцагч хамт олон байна.
- Ажлын байрны болон үйлчилүүлэгчдийн аюулгүй байдлыг ханган, аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэн ажиллана.
- Бид нөхцөл байдлын өөрчлөлтөнд гүйцэтгэлийн болон удирдлагын дүн шинжилгээ хийж "Нэгдсэн менежментийн тогтолцоо"-г тасралтгүй сайжруулан, байгууллагын алсын хараанд хүрч ажиллахыг эрхэмлэнэ.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРДЛ О.НЯМДАЛАЙ



9001 : 2015



14001 : 2015



45001 : 2018